

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-19

-
- | | |
|--|-------|
| 1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/ | 4-7 |
| 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 8-13 |
| 3. Нийслэлийн цахим шилжилтийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох | 14-19 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 53 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар;
Тасалсан: Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Д.Энхдалай, Э.Энхбаатар, И.Эрдэнэцэцэг, В.Эрдэнэцогт, ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, С.Бат-Эрдэнэ, Ж.Нямцэцэг, М.Пагдадулам, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “Үндэсний дата төв” УТҮГ-ын захирал М.Баттулга, “И-Монгол академи” УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран, Мэдээллийн технологийн үндэсний паркийн захирал Ж.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Д.Энхдалай, Э.Энхбаатар, И.Эрдэнэцэцэг, В.Эрдэнэцогт, ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, С.Бат-Эрдэнэ, Ж.Нямцэцэг, М.Пагмадулам, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “Үндэсний дата төв” УТҮГ-ын захирал М.Баттулга, “И-Монгол академи” УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран, Мэдээллийн технологийн үндэсний паркийн захирал Ж.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийслэлийн цахим шилжилтийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газрын Дэд бүтэц, техникийн хяналтын

хэлтсийн дарга Б.Түмэнбаяр, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ-ын дарга Ч.Хувьзаяа, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Нийслэлийн цахим шилжилтийн талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газрын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтсийн дарга Б.Түмэнбаяр нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал мэдээлэл хангалтгүй байгаа тул уг асуудлыг дахин хэлэлцэхээр хойшлуулав.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 08 минут үргэлжилж, ирвэл зохих 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 53 минут.*

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц 63.6 хувь болсон байна. Ийм учраас 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдааныг нээж байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

1. “Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

3. Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаарх Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулттай гишүүн байна уу. Асуулттай гишүүн байхгүй байна.

Хэлэлцэх асуудал 1.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхлүүлнэ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дээр ажлын хэсгийнхэн мэдээлэл өгч байгаа тул түр хүлээх шаардлага гарч байна. Энэ хооронд сүүлд нэмж орж гишүүдийн ирц танилцуулъя. Анар гишүүн ирсэн, Батшугар гишүүн ирсэн, Ганбаатар гишүүн өвчтэй байгаа. Галбадрах гишүүн ирсэн, Золжаргал ирсэн, Мөнхсайхан гишүүн ирсэн, Ундром гишүүн ирсэн, Цэнгүүн гишүүн ирсэн.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофон нээж өгье.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч, 920,2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын нийт 51 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Улсын төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 211 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардал 148,7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 62,5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус байнгын хороонд харьяалагдах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн 17 төсөл, арга хэмжээнд 122,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 53,3 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Ж.Золжаргал: Жавхлан сайдад баярлалаа. Одоо Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 4 номерын микрофон нээж өгье.

С.Магнайсүрэн: Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 14 тайлан нэгтгэгдсэнээс 10 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан тайлант онд гүйцэтгэл гаргаагүй байна.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 5 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,2 тэрбум төгрөгийн 57 зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 3,1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 20 албан шаардлага, 0,2 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 0,7 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 26 зөвлөмж өгч ажиллалаа.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 14,3 тэрбум төгрөгийн 30 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй алдаанд давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 31,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 16,4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 11 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс 9 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байх ба нийт 4,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний хүрээ хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.

Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж үзвэл 31,5 хувийн санхүүжилтийг олгосон дүнтэй байна.

2.Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд 36 тайлан нэгтгэсэнээс 16 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 19 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Хөгжлийн банканд төрийн аудитын дүгнэлт гаргаагүй болно.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 13 байгууллагад өөрчлөлтгүй, 3 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,6 тэрбум төгрөгийн 116 зөрчил илэрснээс 2,6 тэрбум төгрөгийн 14 төлбөрийн акт, 0,8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсох 28 албан шаардлага, хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлж, 3,2 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 71 зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэлд тайлагналтай холбоотой 1,7 тэрбум төгрөгийн 36 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй үлдсэн алдаанд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 203 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 67,5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 45,6 хувийн санхүүжилтийг олгосон дүн мэдээтэй байна.

Дээр дурдсан аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд,

Төрийн үйлчилгээний И-монгол платформыг санхүүгийн тайланд бүртгэх, цаашид хөгжүүлэлтийн зардлыг капиталжуулах асуудлыг шийдвэрлэх

2-т нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас олгосон санхүүжилт нь татаасны хэлбэрт шилжиж байгаад анхаарч, тус сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад дүн шинжилгээ хийж, сангийн эх үүсвэрийг дэд бүтэц, бүтээн байгуулалтад чиглүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын ачааллыг бууруулах

3-д нь улс улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн бусад эргэлтийн хөрөнгө, дансанд бүртгэлтэй хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч ажиллах

4-д нь худалдан авах ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах

5.Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоон хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах

6.Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх эдгээр болно.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын үр дүн дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Ерөнхий аудитор Магнайсүрэн танд баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой өгсөн мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Золжаргал асуулт асууна.

Би 1 ерөнхий асуулт асуух гэсэн юм Сангийн сайдаас. Энэ салбарын сайдын багц нь 118 тэрбум төгрөг байж байгаад, 79,5 тэрбум болж өөрчлөгдөж байгаа буюу 33 хувиар буурч байгаа юм. Тэгээд энэ нь нөгөө бусад ... тэгвэл энийг тодотголын үеэр асууя.

Өөр асуулттай гишүүн байхгүй тул гишүүд асуулт асууж, дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Үг хэлэх гишүүн байхгүй байна.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Галбадрах танилцуулна.

17.06 цаг.

Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Ингээд мэдээлэл асуултад хариулахаар ажлын хэсгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас, Сангийн яамнаас, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас, Үндэсний аудитын газраас гээд удирдлагууд, газар, хэлтсийн дарга нар ирсэн байгаа. Жавхлан сайдын микрофоныг нээж өгье.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт бэрхшээлийг Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримтлалаа.

Энэ хүрээнд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардал, бүх хөтөлбөр, арга хэмжээг зогсооно. Үүнд, цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо.

Мөн төсвийн байгууллагын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасны зардал, байгууллагаас олгох 1 удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Ингэснээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын 2025 оны батлагдсан нийт төсөв 118.4 тэрбум төгрөгөөс 79.6 тэрбум төгрөг болж, хөрөнгийн зардлаас 12.4 тэрбум төгрөг, урсгал зардлаас 26.5 тэрбум төгрөг нийт 38.9 тэрбум төгрөг буюу 32.8 хувиар буурсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төрийн албаны реформын шинэчлэлийн хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын орон

тоог 9 хувиар бууруулахаар төлөвлөсний дагуу салбарын хэмжээнд нийт 540 орон тоо батлагдсанаас 50 орон тоог бууруулахаар төлөвлөсөн.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийг нийт зардлын хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575,1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1,5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах тухай хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

С.Магнайсүрэн: Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх төсвөөс өөрчлөлтгүй, зарлагыг 53,9 тэрбум төгрөг бууруулахаар төлөвлөжээ.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байгаа. Үүнд,

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь улсын хөгжлийн төлөвлөгөөнд заасанчлан бодлогын хувьд зөв боловч чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалал, бүрэн шинжилгээгүй хийх нь зарим талаараа төрийн үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзэж байна.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх эрхийг олгох асуудлыг судалж үзэх

2.Төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан. Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байж болзошгүйг анхаарч үзэх

3-д нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчид төрийн албаны тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлөгдсөний 1 удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Хуулийн төслүүдийн талаар Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд Номин, Золжаргал. Ингээд хаалаа.

Улсын Их Хурлын гишүүн Номин микрофон нээж өгье.

...../бичлэг тасрав/

Асуултууд хаана бас хариулах уу. 7 дугаар микрофон нээж өгнө үү. 6 дугаар микрофон нээж өгнө үү. Яагаад байгаа юм бол. Ажиллахгүй байгаа юм болов уу. 4 дээр суугаад хариултаа өгчихье. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ. Номин гишүүний асуултад хариулъя. Коп 17 хурлыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардал 2025 оны төсөв дээр нийт Байгаль орчин, уур амьсгалын сайд, Гадаад харилцааны сайд гэсэн 2 сайдын багц дээр 23.5 тэрбум төгрөг туссан байгаа. Энэ 23.5 тэрбумын 8.1 тэрбум нь Копын нарийн бичгийн газар луу төлөх төлбөр, 12.1 тэрбум нь Копын хурлын урьтал олон улсын жижиг дэд хурлууд зохион байгуулах зардал, үлдсэн зардал нь коптой холбоотой хурлын бэлтгэл хангах үйл ажиллагааны зардал гэсэн ийм зардал туссан явж байгаа.

Хөрөнгө оруулалтын зардал дээр бол бүгд мэдэж байгаа. 5 сарын 31-ээр копын бүтээн байгуулалт барих 50 тэрбум төгрөг төрийн хэмнэлтийн тухай хуулиар хураагдаад, бид Засгийн газраас 2025 оны төсөв дээр хөрөнгө оруулалтын зардал 41 тэрбум төгрөг ахиж оруулж ирсэн ийм байдалтай байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Номин гишүүнд нэмэлт цаг өгье. Унтраагаад асаах шаардлагатай гэж байна. 5 минут завсарлаад үргэлжлүүлье.

Номин гишүүний микрофон нээж өгнө үү.

Ч.Номин: Энэ нийтдээ л ерөөсөө урсгал дээрээ коптой холбогдолтой 23 тэрбум төгрөг л тавигдсан гэж ойлгож болох уу. Зөвхөн урсгал талаа л.

Ж.Золжаргал: 4 дүгээр микрофон.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам Зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Номин гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. 23.5 тэрбум төгрөгийн урсгалтай холбоотой Коп хурлын бэлтгэл ажлыг хангах ийм зардал батлагдсан байгаа. Энэ 23.5-ын задаргааг дурдвал Гадаад хэргийн сайд дээр 20.4 тэрбум төгрөг туссан байгаа. Энэ 20.4 тэрбум төгрөгөөс ажлын албаны үйл ажиллагааны зардал 1.3 тэрбум төгрөг, дээд түвшний уулзалт, ажлын хэсгийн хурал зохион байгуулах, зөвлөгөөн, сэдэвчилсэн арга хэмжээ хийх 11 тэрбум төгрөг, Коп 17 конвенцын нарийн бичгийн газрын дарга нарын газарт төлөх энэ хураамж 8,1 тэрбум төгрөг байгаа. Ингээд 20,4, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцад 3 тэрбум 60 сая төгрөг туссан байна. Энэ зардлаар бол цөлжилтийн эсрэг нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах хурлын бэлтгэл ажлыг хангах ийм зүйлд зарцуулагдана.

Ж.Золжаргал: Баярлалаа Номин сайдад хариуллаа.

Би нэг ийм асуулт асуух гэсэн юм Сангийн сайдаас. Төсөв тодотгох гээд хэрэгцээ шаардлага гаргаад, тооцоо бол ингээд ороод ирж байгаа. Гэхдээ ийм жижигхэн хэр нь бага хэмжээтэй үнийн дүнтэй хэр нь чухал төсвүүд байгаад байдаг. Инновацыг дэмжинэ гээд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд виртуал бүстэй болно гээд, дэмжинэ гээд их амлалт өгчихсөн. Одоо энэ залуучууд ингээд хүлээгээд байгаад байгаа. Виртуал бүсийн хувьд тендерийг нь зарлаад, сонгон шалгаруулалт нь бэлэн болоод 300 сая төгрөгийн ийм дэмжлэгийг ай тичдад өгөх, нөгөөх нь болохоор инновацын грант олгох журам батлагдаад сонгон шалгаруулалт нь хийгдээд, нийлбэр дүн нь 200 сая төгрөг л юм байгаа юм. Иймэрхүү юмнуудыг нь шийдэж өгч болохгүй юу. Та төсвийн ажлын хэсэгтэй ярьж байгаад шийдэх боломж байдаггүй юм болов уу гэсэн ийм асуулт байна. Ер нь зүгээр сайдын багц бол 118 тэрбумаасаа 33 хувиар буугаад, 79,5 тэрбум хүртэл хамгийн ихээр танагдчихсан байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр анхаарч өгөөч л гэсэн хүсэлт байна. Ийм боломж байх болов уу.

Б.Жавхлан: Золжаргал даргын асуултад хариулъя. Хэрвээ нэмэх гэж байгаа асуудал бол одоо Засгийн газраас гараад явчихсан л даа. Ажлын хэсэг дээр л саналаа тавих нь зөв байх. Тэгэхдээ ер нь ингээд нэг салбар салбарт хуульд оруулчихсан, аль хэдийн одоо Засгийн газартай, Засгийн газаргүй бараг төсөв хуваарилчихсан ийм заалтууд маш олон салбарын хуулиуд дээр байгаад байдаг юм. Сая арай амжсангүй. Намар бол харин дор хаяж 42 хууль орж ирнэ. Иймэрхүү дэмжлэг, иймэрхүү хуулиар тэр салбарт, энэ салбарт тийм мөнгө өг, тийм дэмжлэг үзүүл энэ тэр гэхихсэн тэд нарыг бүгдийг нь хасна. Харин тэр үед л харин нөгөө төсөв хасна, төсөв тэлээд байна гэдэг гишүүд маань энийг харин сайн хамгаалж, энийг л зоригтой реформ хийх ёстой. Төсвийн реформ, төсвийн зарлагын реформыг хийе гэвэл эндээс л эхэлнэ.

Ж.Золжаргал: Тэгэхээр бид бол хуулиуддаа өөрчлөлт оруулж элдэв юм амлахаа болих нь байна. Эсвэл намар 2026 оны төсөв дээр тэр инновац, технологи хөгжүүлж байгаа хүмүүсээ яаж дэмжих вэ гэдэг асуудлаа дахиж ярих хэрэгтэй болох нь гэж ойлголоо. 5 номерын микрофон нээж өгнө үү.

П.Алтан-Од: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Манай төсвийн ерөнхийлөн захирагчийн багц дээр 118 тэрбум төгрөгөөс одоо бол 79,5 тэрбумаар төсөв тодотгол өргөн баригдаж байгаа. Ер нь сая Байнгын хорооны даргын хэлдэг төсөв бол цахим шилжилт арга хэмжээ буюу 17 тэрбум төгрөгийн Засгийн газрын тогтоол, хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх хэмжээний салбар 14 байгууллагын, харьяа байгууллагуудын төсөв саналууд ирдэг. Энийг санхүүжүүлэх дүн бол 17 тэрбумаас 858 сая төгрөг болтлоо буурсан. Тэгэхээр энийг цаашид санхүүжүүлэх хэмжээний бид нар дээр 32 төрлийн гэрээ байгуулагдсан ажлууд байж байгаа. Хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй ажил нь дууссан. Яам бол актаа хөтөлсөн. Сангийн яам дээр гүйцэтгэлээ хүлээгдэж байгаа ажлуудын 2,6 тэрбум, бас протоколд тэмдэглүүлэхэд Радио телевизийн үндэсний сүлжээ буюу гамшгийн үеийн бэлэн байдлын радио телевизийн дамжуулах сүлжээ өнөөдөр 2 цэг дээрээ тасалдал үүсэж байгаа. Тэгэхээр энэ байдал дээр цахилгааны үнэ өссөнтэй холбогдуулаад урсгал зардал дээрээс төсөвлөгдөөгүй зардлууд хасагдаж байгаа учраас бас цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах, байгууллагууд дээр, харьяа байгууллагууд дээр байгуулсан гэрээнүүдийн хэрэгжилтийг хангах гээд Шүүхийн захиргааны хэргийн шүүхийн процесс руу орохоор манай дээр бол ингээд 40 орчим ажлууд явагдаж байгаа учраас цаашид бас манай Байнгын хорооны гишүүд маань Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулган дээр бас тодорхой саналууд гарч ирвэл бас энэ асуудлуудыг харгалзан үзэж шийдвэр гаргаж өгөхийг та бүхнээс хүсье.

Ж.Золжаргал: Нэмэлт мэдээлэл өглөө. Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байвал нэрээ өгнө үү. Мөнхсайхан гишүүн нэр өглөө. Сангийн сайддаа баярлалаа.

Т.Мөнхсайхан: Та бүхэнд оройн мэнд. Тэгээд энэ Сангийн яамныханд бас хэд хэдэн юм хэлчихмээр байгаа юм. Та хэд энэ төсвөө тооцоолж, хасаж тооцохдоо цаад үр өгөөжийг нь нэлээн сайн бодолцож хасмаар байна. Одоо жишээ нь манай эрүүл мэндийн салбарт цахим бодлогын арга хэмжээ дээр байгаа төсвийг тэр чигээр нь хасчихсан байгаа. Тэгээд энэ цахимжилтын арга хэмжээ чинь цаашдаа хэрэгжээд явах юм бол эргээд эрүүл мэндийн салбар, тусламж, үйлчилгээ, хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, бүтээгдэхүүнээс хэчнээн, энийг хэд дахин нугалсан илүү төсвийн хэмнэлт хийх боломжийг бүрдүүлэх төсөв байхгүй юу. Гэтэл энийг нь хасаад хаячхаж байгаа юм.

Тэгээд дээрээс нь Эрүүл мэндийг дэмжих сангаас нэлээдгүй хэдэн тэрбум төгрөг хасчихсан байгаа юм. Энэ дэмжих сан чинь гадаадад эмчлүүлж байгаа иргэдийг дэмждэг гол сан шүү дээ. Хүүхэд бол 50 хувийнх нь төлбөрийг төлдөг. Насанд хүрсэн хүн бол 20 хувийнх нь төлбөрийг төлдөг. Та нар өнөөдөр энэ сангаас хассанаараа хэчнээн хүнийг гадаадад эмчлүүлээд ядууралд өртөхөөс сэргийлж болох байсан чухал төсвийг хасаад, хэчнээн хүнийг эрүүл мэндээс болж ядууралд өртөж байгаа энэ тооцоо судалгаагаа хийж байна уу. Эрүүл мэндийн салбараас нийт ажилчдаас нь 9 хувийг хасна гэж байгаа юм. Тэгэхдээ эмчээс бусдаас нь хасна гэххэж байгаа юм. Гэтэл манай улс чинь 10 мянган хүнд ноогдох эмчийнхээ тоогоор дэлхийд 7-д явдаг. Тэгээд эмч, сувилагчийнх нь харьцаа алдагдаад, сувилагч нь дутагдаад байгаа. Гэтэл эмчээс нь хасахгүй бусдаас нь хасна гэдэг ийм тооцоолол

хийгээд оруулаад ирчихсэн. Тэгээд энэ чинь өөрөө эргээд эмнэлгийн үйл ажиллагаа доголдоход маш их сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Та нар энийгээ маш сайн тооцоолдог, боддог, судалгаа хийдэг байхгүй бол эрүүл мэндийн салбарыг хариуцсан нэг мэргэжилтэн эрүүл мэндийн салбарын бодлогыг тэр чигээр нь санхүүжилтийн бодлогыг хийгээд, тооцоолоод төсөвлөөд ингээд оруулаад ирж байгаа байхгүй юу. Энийгээ та хэд маань жаахан бодолцож үзэж ингэж өөрчлөхгүй бол энэ арга барилаараа яваад байх юм бол дахиад өөрчлөлт гарахгүй. Нийгмийн эрүүл мэндийн бодлого гэдэг чинь өвчин тусахаас нь сэргийлж байгаа юм. Тэр төсвийг дийлэнхийг нь хасчихсан. Энийг хэрэггүй гэж үзээд байх шиг байна. Бид нар өвчин туссаных нь дараа эмчлээд байх юм бол хэзээ ч дийлэхгүй. Энэ төсөв чинь жил ирэх тусам ингэж данхайсаар л байна. Гэтэл яг энэ өвчнөө багасгадаг нийгмийн эрүүл мэндийн бодлогод тавигдсан төсөв мөнгийг нь бүгдийг нь хасчихсан. Энэ ингээд цаашид гарах үр өгөөжийг нь та хэд маань сайн тооцоолж, судалж бодолцож үзэж байж энэ төсөв дээрээ тэр энэ хэмнэлт, хасалт, юмаа хийж байгаач гэж та бүхнээсээ хүсэж байгаа юм.

Тэгээд дараа дараагийнхаа төсвүүд дээрээ та хэд маань энийг анхаараад, тооцооллуудаа нарийн сайн хийгээд, яамтайгаа нэлээн сайн ярилцаад ойлголцоод мэдээж энэ чинь хасах тодотгол хасна гэдгийг ойлгож байгаа. Хэдэн төгрөг хасах юм гэдгээ тодорхой болгоод, мэргэжлийн хүмүүсээс нь саналыг нь аваад, алинаас, хаана, хаанаасаа хасах нь зөв юм бэ, зүйтэй юм бэ гэдэг энэ зүйлүүд дээрээ ярилцдаг байхгүй бол ингээд тооцоолж байсан төлөвлөж байсан ажлууд бүгдээрээ тасалдаад яамны ажил бодлого, санхүүжилтийн бодлого Сангийн яам дээр явдаг энэ байдлаасаа бид нар салахгүй бол цаашдаа бид нар амжилтад хүрэхгүй байна шүү. Энийг та хэд маань анхаараарай гэж хэлэхийг хүссэн юм. Баярлалаа.

Ж.Золжаргал: Мөнхсайхан гишүүн ганцхан эрүүл мэндийн салбарт чинь эмч биш, ард нь зөндөө олон мэргэжлийн хүмүүс ажилладаг гээд яриад мэдээлээд байсан. Сонссон л доо. Ер нь бол энэ чинь төсөв тодотгоод хасах шаардлагыг нь бол ойлгож байгаа. Гэхдээ хаанаасаа хасах вэ гэдэг асуудал байна шүү дээ хүнээсээ биш, энэ байшин сав, барилга, цемент иймэрхүү зүйлээсээ л илүү түлхүү хас. Тэрэнтэй холбоотой урсгал зардлуудаа бууруулмаар байгаа гэдгийг бас давтаад хэлье.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор гаргана гэж заасны дагуу зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Ингээд төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

17.37 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3.

Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох.

Ингээд хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газрын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтсийн дарга Түмэнбаяр, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ-ын дарга Хувьзаяа, Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжийн төслийн зохицуулагч Булгаа, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Отгонжаргал нар ирсэн байна.

Ингээд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн танилцуулгыг Даваадалай танилцуулна. 5 дугаар микрофон нээж өгнө үү.

Т.Даваадалай: Эрхэм байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Улаанбаатар хотод хэрэгжиж буй цахим шилжилттэй холбогдолтой танилцуулгыг хийе.

Улаанбаатар хотод 2025 оны байдлаар нийт 8 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Нийслэлийн Телекамерын нэгдсэн төв байгуулах авто замын бүрэн камержуулах төсөл, нийтийн тээврийн цахим шилжилт, Улаанбаатар дата центр, Онлайн бизнес, Хог ангилах ухаалаг хогийн савны систем, Юбичат, ус хэрэглэгчдийн нэгдсэн мэдээллийн систем болон Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төсөл гэсэн үндсэн 8 төсөл, арга хэмжээ бол хэрэгжиж байна.

1 дүгээрт нь нийслэл Улаанбаатар хотын телекамерын нэгдсэн төв байгуулах, Авто замыг бүрэн камержуулах төсөл хөтөлбөр. Энэ төсөл хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд шинээр байгуулагдсан нэгдсэн 1 болон 9 дүүргийн дүүргүүд дээр дэд теле камерын хяналтын дэд төвүүд байгуулж, хоорондоо өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбогдсон. Төвийн 6 дүүрэг нь 40 гигабайт, алсын 3 дүүрэг 100 мегабайтын урсгалаар холбогдсон төсөл амжилттай хэрэгжиж сая өнгөрсөн 7 хоногт 9 дүүрэг болон нийслэлийн хэмжээнд нээлтээ хийгээд байна.

Улаанбаатар хотын өмнө нь бид бүгд камерыг дур мэдэн суурилуулдаг, ашиглалт үйлчилгээ дээр хяналт тавьдаг нэгж байхгүй, нэгдсэн байдлаар бус өөр өөрсдийн хэсэгчилсэн байдлаар ийм өрөөнүүд дээр үйл ажиллагаагаа явуулдаг байсан бол одоо бүх камерын удирдлагын системүүдийг нэг доор төвлөрсөн байдлаар дүүргүүд дээр бас нэгтгэж, камер бүр харьяа удирдлагын дэд төвүүд дээр холбогдон удирдлагын дэд төв, нэгдсэн удирдлагын төвтэй цогц байдлаар нь бол шийдсэн. Ингээд 9 дүүргийн хяналтынх дээр одоо байгаа дүүргийн камерууд, гэр хорооллын гудамжны камерууд, нийтийн тээврийн, сургууль, цэцэрлэг, хувийн аж ахуйн нэгжүүдийн камерыг нэгдсэн байдлаар бол төвлөрүүлээд ажиллаад дууссан. Та бүхэн бас төслүүдийн зургийг харж байна. Нийт төслийн гүйцэтгэл бол 97 хувьтай.

Улаанбаатарын хэмжээнд 176 уулзвар байгаагаас зөрчил илрүүлэх боломжтой 150 уулзвар. 150 уулзвар дээр төсөл хэрэгжсэнээс 5 уулзвар дээр одоогийн байдлаар цахилгааны гэмтэл, шилэн кабелийн гэмтэлтэй гэсэн 5 уулзвар дээр бол төслийг үргэлжлүүлж байна. Бусад 145 уулзвар дээр бол төслийг гүйцэтгэж бол нээлтийг хийж ажиллагаанд оруулсан байж байгаа.

Зөрчил илрүүлж иргэдэд сануулах мессеж хүргэж буй 136 уулзвар, нийт гүйцэтгэл ингээд 93 хувьтай. Зөрчлийг гэрлэн дохио автомашины урд болон хойд улсын дугаар 180 градусын уулзварын хяналтын зөрчил илрүүлэх Монгол Улсын хууль тогтоох журмын дагуу хөдөлгөөний дүрмийн дагуу системд бол оруулсан. AI системтэй. Зөрчлийн мэдээллийг нотлох баримтын түвшинд хүртэл үүсгэн баталгаажуулаад ажиллаж байгаа. Үүн дээр гэрлэн дохио, замын зураас тэмдэглэгээнүүд, машины өнгө, марк, урд хойд улсын бүртгэлийн дугаарууд гэх мэт мэдээллүүд орж байгаа. Нийт 150 бүрэн камержуулсан уулзвар дээр 10 төрлийн зөрчлийг илрүүлэхээр хуульд заасны дагуу байгаа. Эгнээ байр буруу эзэлсэн, гэрлэн дохио зөрчсөн, зогсох шугам давсан, урсгал сөрсөн, үргэлжилсэн цагаан шугам давж эргэсэн, түр зогсох хориотой газар зогссон, хурд хэтрүүлсэн гэх мэт зөрчлүүдийг бол ноогдуулж, илрүүлэх 10 төрлийн зөрчил 150 байршил дээр бол боломжтой болж байгаа. Хуучин бол 24 байршил дээр 44 камераар зөвхөн 5 төрлийн зөрчлийг илрүүлдэг байсан. Тэгээд өдөрт 5-7100, сардаа 150 мянга гаруй зөрчлийг нийт эрх бүхий 15 албан тушаалтан баталгаажуулдаг байсан нь бол ажлын ачаалал бол маш их зөрчлийг илрүүлэх баталгаажуулалт хүрэхгүй ийм байдалтай бол өмнө нь бол байсан. Гэвч одоо энэ нэгдсэн төв ашиглалтад орсноороо Улаанбаатар хотын 176 уулзвар дээр 2606 камер суурилуулагдаж, төвлөрсөн байдлаар орчин үеийн системээр бүгдийг нь холбож 10 төрлийн зөрчлийг бол цаашид илрүүлэх ийм боломжтой болоод байна.

Өнгөрсөн 7 хоногийн хувьд хөдөлгөөнд нийт 486 мянга орчим тээврийн хэрэгсэл оролцож, үүнээс орон нутгийн 93 мянга гаруй тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн. Илрүүлсэн зөрчлийг өдрөөр нь ангилж үзвэл зөвхөн 1 өдөрт буюу 29-ний өдрийг авч үзэхэд 6 төрлийн зөрчил 68 мянга гаруй орчим тээврийн хэрэгсэл зөрчилтэй байгаа харагдаж байна. Үүнээс 14 хоногийн өмнө төлөөгүй торгуультай 12969, үзлэгийн хугацаа дууссан 8207 гэх мэт зөрчлийн төрлүүдийг бол ингээд ангилсан байна.

Зөрчлийг баталгаажуулахад 3 мянган ажилтан хэрвээ хуучин уламжлалт байдлаар бол ЭБАТ буюу эрх бүхий албан тушаалтан шаардлагатай болж байсан. Үүнийг орчин үеийн дэвшилтэт AI технологи, хиймэл оюун ухаан, их дата өгөгдөлтэй, суурилуулж ажиллуулахад орчин, хууль, эрх зүйг бол бэлдээд байгаа.

Камерын хяналтын улсын бүртгэлийн дугаар, өнгө, төрөл, үйлдвэрлэгчийн таних бөгөөд авто тээврийн хэрэгслийн сантай шууд тулгалтыг хийж ямар нэгэн алдаа гарахгүй, шууд таарч байгаа тохиолдолд зөрчлийг шууд баталгаажуулж, харин тулгалт зөрсөн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан давхар хянахаар ийм зохицуулалтыг хийж, ажлын байрыг хэмнэж, ухаалаг систем рүү орсон тээврийн системийг нэвтрүүлээд байна.

Мөн цаашид нийслэлийн энэ телекамерын нэгдсэн удирдлагын төвийг 21 аймгийн дэд төвүүдтэй холбох, дээрээс нь нийслэлийн болон улсын тусгай чиг үүргийн байгууллагууд нэгдсэн мэдээллийн системд холбогдож мэдээллийг бол шууд авч байгаа. Энэ бол ТЕГ, ЯАБЗ, ЦЕГ, онцгой байдал гэх зэх төрийн тусгай чиг

үүргийн байгууллагууд бол нэгдсэн байдлаар албан мэдээллүүдийг шууд авч явах боломжтой байж байгаа.

Системийн хувьд болохоор системийн давуу тал нь олон төрлийн үйлдвэрлэгчтэй камерыг нэгтгэж, нэгдсэн удирдлагаар хангах нэгдсэн төв болсон. Дэд төвөөс мэдээллийг тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд бол өөрийн хуульд заасан эрхийн хүрээнд шууд авах боломжтой. Тэгээд ингэснээрээ бол гэмт хэргийг хурдан илрүүлэх зөрчлөөс сэргийлэх, дээрээс нь зарим симуляц, дата бүхий мэдээллүүдийг авто замын ялангуяа систем дээр уулзваруудын original destination гэх мэт түгжрэлийн холбогдолтой судалгаануудыг бол нэгдсэн байдлаар хийх ийм боломжуудыг бүрдээд байж байгаа. Эхний төслийн хувьд бол ийм байна.

2 дугаар төслийн хувьд бол нийтийн тээврийн цахим шилжилт гэсэн төсөл байж байгаа. Бид өнөөдөр Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн салбарын томоохон цахим шилжилтийг хийж байна. Бид нийтийн тээврийн үйлчилгээг зөвхөн нийтийн тээврийн картаар зорчих бус олон улсын болон дотоодын бүхий л банкны картаар зорчих боломжтой болгож, иргэдэд нийтийн тээврийн аппликэйшн ашиглаж, иргэд төлбөр төлөлтөөс хийхээс гадна нийтийн тээврийн бодит цаг хугацаа, мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлээд байгаа.

Цахим шилжилт нь дан нийтийн тээврийн бодлогын хүрээнд систем нийлүүлэгдэж, түүн дээр ажиллах асуудал биш бөгөөд дараах зүйлсийг үе шаттай хөгжүүлээд байна. Үүнд,

Нийтийн тээврийн парк шинэчлэл, системтэй холбогдож ажиллах автобусанд суурилагдах тоног төхөөрөмж, 10-12 төрлийн тоног төхөөрөмжүүдийг автобусанд суурилуулсан. Үүнд, хүн тоологч камер, нийтийн тээврээр зорчиж буй зорчигчийн тоог тоолох, жолоочийн хяналтын камер, жолооч нарын үйлчилгээнд явж буй төрөл байдал, жолоочийн зөрчлийг хянах дотор хяналтын камерууд, бодит цаг хугацаагаар тухайн автобуснуудыг хянах урд арын хяналтын камер гэх мэт мэдээллүүдийг бол хянаж байгаа. Иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг ойрхон хүрэхийн тулд киоск машинуудыг 100 байрлал дээр байршуулсан. Нийтийн тээврийн үйлчилгээг хянах, төлөвлөх боломж бүхий нийтийн тээврийн удирдлагын систем салбарын хэмжээнд буюу нийтийн тээврийн бодлогын газар ашиглах төлбөр тооцооны менежментийн систем болон дэд 8 системийг иргэдэд ашиглах иргэдийн аппликэйшн, дэд систем, карт түгээх киоскийн систем, арт борлуулах мерчендайтын систем гэх мэт системүүдийг бол хөгжүүлээд байгаа. Мөн тасалбар уншигч, валидатар программ, засвар үйлчилгээний аппликэйшн, лед дэлгэц, удирдлагын систем, нээлттэй мэдээллийн сан, интеграц, нэмэлт хөгжүүлэлт зэрэг системүүдийг бол нийтийн тээврийн цахим шилжилтээр бол гүйцэтгээд байгаа.

Цахим шилжилтийг бий болгож буй томоохон хүчин зүйлүүд болох систем болон иргэдэд ашиглах аппликэйшний давуу тал боломжуудыг бол бид нар өргөн харж байна. Тухайн систем нь аппликэйшн нь иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийг бол нэмэгдүүлэх боломжийг бол үүсгээд байгаа. Нийтийн тээвр дээр 4 төрлийн сонголтыг үүсгэж байгаа. Улаанбаатар карт аппаар, юби карт аппликэйшнээр орох Улаанбаатар карттай болох, киоскоор мөн хандах, бүх нийтийн тээврийн картаар бол төлбөрийг гүйцэтгэж болно.

Мөн энэ 4 төрлийн үйлчилгээг сонголтыг иргэдэд олгосон бөгөөд иргэдэд аппликэйшнээр дамжуулан Кю ар кодоор уншуулан зорчилт хийхээс гадна

хөнгөлөлттэй зорчигч болон ахмад настан зэрэг иргэдэд хур, дан системүүдээр танилт хийгдэн систем дээр бүртгэл үүссэнээрээ аппликэйшн ашиглалт зорчилт хийх боломжийг мөн бүрдүүлсэн. Мөн 4 удаагийн зорчилтыг аппликэйшн ашиглан хийх бас мөн боломжтой болгосон.

Нийтийн тээврээр зорчих биет карт, өөртөө үйлчлэх киоск төхөөрөмж, өөртөө үйлчлэх киоск төхөөрөмжийг иргэдийн байнгын ордог үйлчилгээний 100-аад байрлалууд дээр байршуулсан бөгөөд киоск төхөөрөмжөөр дамжуулан иргэд биет карт худалдан авах боломжтой. Өөрт байгаа биет картаа цэнэглэх, 1 удаагийн зорчих тасалбар авах мөн боломжуудыг бүрдүүлсэн. Бүх төрлийн гадаадын болон дотоодын банкны картууд бол мөн аппликэйшн дээр 2025 оны 2 дугаар сараас эхлэн нэвтрүүлээд уншиж байгаа. Сар бүрийн татан авалтын тоо өсөж байгаа бөгөөд сүүлийн 5, 6 сарын байдлаар нийтийн тээврийн санд анх удаа 1 тэрбум төгрөгөөс дээш бол борлуулалт хийгдсэн ийм амжилттай үр дүн тухайн карт цахим шилжилтийг хийснээр бол бүртгэгдээд байна.

Нийтийн тээврийн үйлчилгээг хянах төлөвлөх боломж бүхий нийтийн тээврийн удирдлагын систем. Энэхүү удирдлагын систем нь нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтуудыг хийдэг бөгөөд нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй аж ахуйн нэгжүүдийн автобуснуудад суурилагдсан тоног төхөөрөмжтэй холбогдон ажилладаг. Үүнд, жолоочийн хяналтын камер, иргэдийн бухимдлыг байнга төрүүлдэг нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй жолооч нарын үйлдлүүдийг хянах, арга хэмжээ авах, сайжруулах бүрэн боломжтой ба жолооч нарын гаргадаг зөрчлүүдийг төрөл бүрээр нь бүртгэж, хяналт хийх арга хэмжээ авах боломжтой болгож байгаа. Тоног төхөөрөмжүүд суурилагдаж, систем нэвтэрснээр жолоочийн зөрчлийн тоо байнгын буурч, тодорхой зөрчлүүд бол арилж байгаа. Одоо та бүхэн бичлэг дээр харж байгаа. Жолоо барих үедээ утсаар ярих, тамхи татах гэх мэт үйлдлүүд бол камерт бүртгэгдэж цаашид бид нар аж ахуйн нэгжийн удирдлагууд болон жолооч нартаа эдгээр алдаа дутагдлуудыг засаад явах боломжийг бол бүртгэж байгаа.

Хүн тоолох тоологч систем нь болохоор нийтийн тээвэр зорчиж буй зорчигчийг тоолж, бодит цаг хугацаагаар тоон мэдээллийг харж орлогыг бас хянаж явах ийм боломжийг бүрдүүлж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээг хянах зорилгоор бүх үйлчилгээ болон автобус компаниудын мэдээллийг боловсруулан нэгдсэн хяналт хийх дашбоардууд байгаа бөгөөд бодит цаг хугацаа дээр видео дүрслэлийг харуулж байгаа.

Мөн энгийн иргэдээс гадна хөнгөлөлттэй зорчигч, албан хаагчдыг аппликэйшнээр болон картаар дамжуулан зорчилтыг бүртгэж, зорчилтын орлогыг тухай бүүр хяналт хийх бүрэн боломжтой болж байгаа. Дээрх график зорчигч тоологчийн тоон мэдээлэл болон системийн зорчилтын тоон мэдээллүүдийг бас мөн харьцуулан харууллаа. Нийтийн тээврийн төлбөрийн системийг шинэчлэн бүх төрлийн банкны карт болон гар утсаар төлбөр хийх боломжийг бүрдүүлснээр иргэдийн өдөр тутмын зорчих үйл ажиллагаа хялбаршиж, нийтийн тээврийн орлого хяналт сайжирсан. Үүний үр дүнд зорчигч тооллогын нарийвчлал нэмэгдэж, үйлчилгээний ил тод байдал хангагдаж байгаа. Цаашид нийтийн тээврийн сүлжээг өргөжүүлж, трамвай, метро, дүүжин тээвэр такси, байгальд ээлтэй эко ногоон онооны систем, зогсоолын ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхэд иргэдэд илүү хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй тээврийн тогтолцоог бүрдүүлэх суурь үндсэн дижитал платформ болж хөгжиж байгаагаар мөн бас онцлогтой байна.

3 дугаар төсөл бол Улаанбаатар дата центр. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2024-2025-ны оны хооронд олон улсын TR-4 зэрэглэлийн Дата центрийн төвийг Монгол Улсын хэмжээнд анх удаа ашиглалтад оруулаад байна.

Тус дата төвд одоогоор нийт 80 физик сервер, 247 виртуал сервер, 48 сүлжээний төхөөрөмж, 4 хамгаалалтын галт хана, 130 дэд системүүд байршиж байгаа бөгөөд цаашид нийслэлд хэрэгжүүлж буй дэд системүүдийг байршуулах, дэд бүтцийн боломжийг суурь Ай ти-ийн дэд бүтцийг бүрдүүлсэн ийм онцлогтой төсөл болсон /минут дуусав/

Ж.Золжаргал: Даваадалай дарга үлдсэн гол мэдээллийг төслийнхөө хэмжээг, ач холбогдлыг нь яг техникийн шийдэл ярихаасаа илүүтэйгээр товчхон хэлээд яваарай. Тэгээд би 2-т нь бас гоол бодоод байгаа зүйл Монгол Улсын хэмжээнд нэвтрүүлсэн цахим шийдлүүд, системүүд, программ хангамжууд, тэгээд энийг бүх салбараас гаргаж аваад, хүснэгтлээд Монгол улсын Ерөнхий сайд, Боловсролын яам, БХБЯ, БХЯ гээд бүгд жагсаалттай байгаа. Энэ дээр НЗДТГ-ын зүгээс худалдаж авсан цахим системүүдийн мэдээлэл ирээгүй юм. Энийг ирүүлэх гээд бичиг явуулсан байгаа. Тэгэхээр энэ дээр бол бүх жагсаалтууд, өнгөрсөн хугацаанд худалдаж авсан программ хангамж, цахим юмнууд зарим нь ажиллаж байгаа, зарим нь ажилладаггүй, зарим нь системдээ таардаггүй. Тэр нь бол бас байх л үзэгдэл. Хэд нь ажиллахгүй байна, хэдэн төгрөгөөр авсан гээд. Тэгэхээр ямар шийдлүүдийг энд байгаа шийдлүүдийг энэ төслүүд нь тус бүрдээ ямар хэмжээний төсөвтэй ажил болсон юм. Тэр төсөв нь улсын төсвөөс гарсан юм уу, гадаадын зээл тусламжаар хэд байна. Одоо цаашдаа хэдэн төгрөгөөр төлөвлөгдөж байгаа вэ гээд энэ мэдээллүүдийг сонсмоор байгаа шүү. 5 номерын микрофон нээж өгье.

Т.Даваадалай: Золжаргал гишүүний өгсөн үүрэг даалгаврыг тэмдэглэж авлаа. Танд удахгүй мэдээллийг бас ойрын хугацаанд хүргэе.

Ж.Золжаргал: Үгүй ээ, уучлаарай Даваадалай дарга аа, энэ мэдээллийг өнөөдөр энд сонсох гэж хурал зарласан. Тэгэхээр хэрвээ та бүхэн тэр хүснэгтийг бэлдээрэй гээд Байнгын хорооноос мэдээлэл хүргүүлсэн. Тэрийг бэлдсэн юм уу үгүй юу. 6 номер дээр.

Б.Түмэнбаяр: Түмэнбаяр хариулъя. Систем дээр ерөнхийдөө яг одоо нийслэл дээр хэрэгжиж байгаа цахим системийн явцыг танилцуулаарай гэсэн болохоос яг өмнө нь хэрэгжүүлсэн хэдэн төгрөгөөр ...

Ж.Золжаргал: Хэн тэгж хэлсэн юм. Явцыг танилцуулаарай гэж.

Б.Түмэнбаяр: Бат-Эрдэнэ даргаас над руу ерөнхийдөө холбогдож мэдээлэл өгсөн. Тэгээд яг одоогийн байдлаар нийслэл дээр хэрэгжүүлж байгаа төслүүд, мэдээлэл цахим шилжилттэй холбоотой төслүүд нь ямар төслүүд байгаа вэ гэдэг байдлаар танилцуулга хийх юм байна шүү гэж.

Ж.Золжаргал: Тэгэхээр нийт нэвтрүүлсэн цахим системийн жагсаалт, төсөв, гүйцэтгэл, хэд нь гадаадын зээл тусламж гэдэг мэдээлэл одоогоор танд байхгүй гэсэн үг үү.

Б.Түмэнбаяр: Уг нь манай дээр байгаа. Яг нэгтгэсэн байдлаар бол гараагүй байгаа. Уг нь түүнээс жил жилээрээ бол системүүд дээр манайх тайлангуудаа гаргаад явж байгаа.

Ж.Золжаргал: Тэгвэл ингэе. Энэ танилцуулгыг бол талаас илүүг нь сонслоо. Тэгээд та бүхнийг ажилтай хүмүүсийг дуустал нь сонсоод яах вэ. Гол шаардлагатай юм бол Нийслэлийн цахим дэд шилжилтийн хүрээнд ямар төслүүд, ямар хугацаанд хийгдсэн, хэдэн төгрөг зарсан, тэд нараас хэд нь ажиллаж байгаа, гадаадын зээл тусламжаар хэдэн төгрөгөөр, хэдэн доллараар хэдэн ажил хийгдэж байна. Одоо саяын энэ танилцуулж байгаа энэ төслүүд маань тус бүрдээ ямар төсөвт өртгөөр хийгдсэн бэ гээд энэ мэдээллийг бэлдэхийг та бүхнээс хүсэж байна.

Тэгээд энэ хэлэлцэх асуудлыг хойшлууллаа. Дараагийн хурлаар дараа нь тэр нь Байнгын хороо байна уу, дэд хороо байна уу, Эдийн засгийн хороо байна уу ямар ч байсан үргэлжлүүлээд явна.

2 дугаарт нь албан бичгээр асуулга хүргүүлсэн байгаа. Тэр дээрээ хариулт бэлдэж яаралтай ирүүлэхийг хүсье. Тэгээд энэ ерөөсөө хүний хийж байгаа ажилд гай болж байгаа юм биш шүү. Энэ чинь улсын төсөв нийтийн төлөө хийгдэж байгаа ажил. Тийм болохоор хувийн хэвшлийг биш учраас хариулт тайлбарыг нь өгөх л ёстой. Миний асуугаад байгаа асуулт бол маш тодорхой. Төслүүд, хэрэгжилт, гүйцэтгэл, зарцуулсан төсөв, дараа нь зарцуулах төсөв. Тэгээд энэ мэдээллээ бэлдэж байгаад хурлаа хойшлуулаад, товыг нь жич та бүхэнд хүргүүлье.

Ингээд энэ асуудлыг хойшлуулчхаж байгаа юм чинь асуулт асуух, үг хэлэх зүйл байхгүй. Та бүхэнд баярлалаа.

Ингээд өнөөдрийн байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөснийг мэдэгдье.

18.01 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ